

## МОНГОЛ ХЯТАДЫГ ДАЙРСАН ХУЙ САЛХИ

3 сарын дундуур Монголын нутгаар их хүчтэй элсэн шуурга болсон бөгөөд батлагдаагүй эх сурвалжуудын мэдээлснээр энэ хуй салхи баруун Монголоос эхлэлтэй байжээ. Нийт 9 аймгийн нутагт энэ шуурганаар 8 том хүн 1 хүүхэд, маш олон мал эндэж, 512 хүнийг эрэн сурвалжилж байснаас, 2021.03.15-ны байдлаар 12% нь олоогүй байлаа. Баруун аймгуудаар нэлээдгүй цахилгааны шугам гэмтэж, тодорхой хугацаанд цахилгаан тасарчээ.

Хуй салхи Монголын нутгаас гарч Хятадын хойд хэсгээр Такла Макан цөлийг дайран Бээжин хүрсэн байна. Бээжинд хүрсэн элсэн шуурга Бээжингийн замын хөдөлгөөнийг болон 400 орчим агаарын тээврийг зогсооход хүргэжээ. Энэ салхин шуурга бол сүүлийн 10 жилд болсон хамгийн хүчтэй шуурга байжээ.

Нийтлэгч 2014 онд Бээжингийн онгоцны буудал дээр олон цаг хүлээсний эцэст онгоц



Хятадын хойт нутгаар элсэн шуурга, 2021 оны 3 сар



агаарт хөөрөх мөчид цонхоор харахад хар бараан өнгийн өтгөн шөл, зутан мэт зүйл харагдаж байжээ. Онгоц 5000м өндөрт хөөрч байж тэнгэрийн өнгө цэнхэр болж байв.


Төв Ази болон Монголд хүчтэй салхи, шуурга голдуу хаврын цагт болдог. Хүчтэй салхин шуурганууд болж байсан нэлээд эртний мэдээнүүд ч байдаг. Жишээлбэл салхинд олон гэр хийссэн тухай, мал сүрэг шуурганд уруудаж 100 гаруй км хүртэл уруудаж, хэцүү эрэг сураг болдог байжээ.


Хаврын цагт агаарын хэм дээшилж, агаарын урсгалууд хөдөлгөөнд орсноор ийм аварга салхи шуурганууд гардаг. Говь нутагт болсон шуургануудын жагсаалтыг доорх линкээс үзэж болно.

<https://earthobservatory.nasa.gov/images/80940/dust-storm-in-china-and-mongolia>

Эдгээр салхи шуурганы элс хэдэн мянган км дэлхийн бөмбөрцгөөр тарж бороо цастай холилдон буудаг бөгөөд түүнийг „цусан бороо, цусан цас“ гэж нэрлэдэг. 2021 оны 2сарын эцэс 3 сарын эхээр төв Европт Африкийн Сахарын элс Атлантын далайн дээгүүр, Канарын арлыг дайран дараа нь Европын ихэнх хэсэгт хүрч ирсэн. Германы цаг агаарын газрын мэдээлснээр энэ үед 14 сая тонн элс нүүж иржээ. Элсний ийм

Сахарын элс, 2021 оны 3 сар





Элсэн шуурга, Сахарын цөл, 2021 оны 3 сар

нүүдэл бол энгийн байдаг зүйл боловч энэ жил түүний хэмжээ, хүч илүүтэй байлаа.

Ийм салхин шуурга Говийн цөл нутгаас гадна Сахарын цөл, төв Анатоли, Арабын хагас арал, Хятадын баруун нутаг Такла Макан цөлд тодорхой давтамжтайгаар болдог. Энэ нутгуудаар амьдардаг амьтад байгалийн энэхүү үзэгдэлд дассан байдаг. Жишээлбэл Монгол тэмээ, нэг бөхт тэмээ хамрынхаа нүхийг хааж элс шороо орохоос хамгаалж чаддаг.

Дэлхийн агаарын дулаарлын нөлөөгөөр агаарын урсгалуудын өөрчлөлтүүдээр ялангуяа улирал солигдох үеэр салхи шуурга ихсэж байна.

Иймэрхүү элсэн шуурганууд ихсэж байгаа нь дэлхийн дулааралтай холбоотой боловч цорын ганц шалтгаан нь биш юм. Мөн хүний үйл ажиллагааны үр дагавар байна. Ургамалаар битүүмжлэгдэн цөлжилтөөс хамгаалагдсан газрыг тариалангийн болон бусад эдийн засгийн зорилгоор задалж хагалж байгаа нь газрын элэгдэл, хөрсний эрозийг үүсгэж байна.

Иймэрхүү элсэн шуурганууд ихсэж байгаа нь дэлхийн дулааралтай холбоотой боловч цорын ганц шалтгаан нь биш юм. Мөн хүний үйл ажиллагааны үр дагавар байна. Ургамалаар битүүмжлэгдэн цөлжилтөөс хамгаалагдсан газрыг тариалангийн болон бусад эдийн засгийн

зорилгоор задалж хагалж байгаа нь газрын элэгдэл, хөрсний эрозийг үүсгэж байна.

## Америкт болсон „Dust Bowl“ гэх бэлчээрийн сүйрэл

Америкт 1930-аад онд Окламакийн олон зуун мянган малчид (Окис) ядуурч, хөлсний ажилчид болохоор нутгаа орхих болсон.

Түүний шалтгаан нь тэнд газар тариалангийн зорилгоор газар ихээр хагалсантай холбоотойгоор үүссэн шороон шуурга, хөрсний эвдрэл байв. 1930-аад оны үед Америкийн засгийн газар хөрсний элэгдлийг багасгах зорилготой Hugh Bennett удирдсан „Soil Erosion Service“ байгууллага байгуулж борооны ус тогтоох бэхэлгээ хашлага хийх гэх мэт их чармайлт гаргасан нь өнөөгийн Хятадын „ногоон хэрэм“ хөтөлбөртэй төстэй үйл ажиллагаа байв.

## Зөвлөлтийн атар газар эзэмших компаниг ажил

Хрушевийн Казахстанд явуулсан атаржуулах бодлогын үр дүнд, хэдхэн жилийн дараа хөрсний гэмтэл их явагдсан. Хөрсний хуурайшилтаас гадна үржил шимтэй хөрс давсжиж, хөрс сийрэгжиж, суларснаар эрозийг хурдасгасан.

2011 онд Германд Ростокийн орчим А19 Автобаан дээр айхтар осол гарсан. Ослын шалтгаан нь хуурай шороон салхи хүчтэй тавьж, машинууд бие биедээ үзэгдэхгүй болсон юм.

Иймэрхүү байдлыг Өвөр Монголын талд ч ажиглаж болно. Энэ бол 20-р зууны 2 дахь хагасад хятадуудад газар ашиглахыг зөвшөөрсөнтэй холбоотой. Хятад улс Боксеруудын бослогын дараа дайны төлбөрөө Өвөр Монголд аж ахуй эрхлэх тариачдын татвараар төлөхөөр шийдсэн хэрэг.

Ингэснээр малын бэлчээр байсан газар элсэн цөл болж эцэст нь шуургаар элс нь Бээжингийн тэнгэрт хүрэх боллоо.

Элсэн шуурга бол яахын аргагүй газрыг зохисгүй ашигласан хүний хариуцлагагүй үйл ажиллагааны уршиг юм.

Хятад улс цөлжилтийг зогсоохын тулд „Ногоон хэрэм“ нэртэй хөтөлбөр хэрэгжүүлэхдээ

элсэн хөрсөнд ургах чадвартай ургамал тарьж, хөрсний дээд хэсгийг бэхжүүлэх, аажим аажмаар чийг хадгалах чадвартай үржил шимтэй хөрс бий болгохоор оролдож байна.

Сүүлийн жилүүдэд эдгээр клонын аргаар соёолуулсан таримал бут, бургас моднууд нь хорхой шавжид баригдсан болон бусад шалтгаануудаар олноороо үхэж байгаа боловч хятадууд „Ногоон хэрэм“ хэмээх дэлхийн хамгийн том хөтөлбөрөө үргэлжлүүлсээр байна.

Ногоон хэрэм хөтөлбөрийн тухай мэдээлэл дараах линкүүдээр орж уншиж болно.

<https://www.energie-klimaschutz.de/chinas-gruene-mauer/>

<https://www.heise.de/tp/features/Chinas-Gruene-Grosse-Mauer-4638653.html>

<https://www.youtube.com/watch?v=hPQzybAEIU>

## **Элсэн шуурга үржил шимт, тариалангийн газрыг гэмтээдэг.**

Энэ оны Зсард болсон элсэн шуурга Хархорин суманд ихээхэн хохирол учруулжээ.

Хархорин бол Орхон голын сав газар, аль аль талаасаа уул, модоор хүрээлүүлсэн том хөндийд оршдог. Энэ газар зүйн онцлогт тулгуурлан Монголын нийслэлийг нүүлгэх алтернатив газар ч гэж үздэг. Ийм тохиромжтой нутагт Чингис хааны үед ч хэдэн түмэн морь, малын бэлчээртэй улсын нийслэл байсан бөгөөд одоо орчин цагийн Монголд ч гэсэн чухал үржил шимтэй газар юм. Энэ нутагт Солонгосын тусламжийн байгууллагын дэмжлэгтэй хөрсний хуурайшилтыг багасгах, салхинаас хамгаалах бут тарьж ургуулж байгаа. Энэхүү газар хөрсний эрозиг багасгах, хөрсний хамгаалалт болох бут, бургас саяны салхинд үүргээ гүйцэтгэсэн байгаасай гэж хүсэж байна.





Элсэн шуурга, Хархорин, 2021 оны 3 сар

## LÖSS – ERGEBNIS VON SANDVERWEHUNGEN

Verwehungen von Staub und Sand hat es in der Erdgeschichte immer gegeben. So ist z.B. der Löss-Boden in Mitteleuropa, aber auch der fruchtbare Boden des Lössplateaus Chinas Ergebnis von solchen Verfrachtungen, wo sich der fruchtbare Ackerboden dann im Verlauf von Tausenden von Jahren ausgebildet hat. Während in Mitteleuropa der Löss meist nur wenige Meter und nur an besonderen Stellen bis zu 40 m dick ist, erreicht er in China Mächtigkeiten von bis zu 400 m. Damit sich aber aus dem abgelagerten Sand und Staub wieder solcher Boden bilden kann, sind noch eine Reihe von weiteren Voraussetzungen wie insbesondere Wasser zu erfüllen.



Алтан химэрлэг, Зураг ба газрын зураг



## „ХЯТАД ХЭЛ СУР! ТЭГВЭЛ СОЁЛ ИРГЭНШИЛТЭЙ ХҮН БОЛНО! ӨВӨР МОНГОЛООС МОНГОЛ ХЭЛИЙГ АРИЛГАЯ!“

Өвөр Монголын хэд хэдэн хошуунд ноднингийн 9 сарын 1 нээс эхлэн Монгол сургуулиудад монгол хэл дээрээ явагддаг хичээлүүдийн тоог хязгаарлаж, нэлээдгүй хичээлүүдийг „Хятад хэл сурцгаа, тэгвэл соёл иргэншилтэй хүн болно!“ гэсэн уриа лозунтай хятад хэл дээр явуулахаар Хятадын удирдагчид шийдвэрлэжээ

Ингэж Монгол хэлийг иргэншлийн бус, бүдүүлгүүдийн хэл гэж илтэд гадуурхсан шовинизм бол зөвхөн колоничлогчдын улс төрийн үйлдлүүдтэй зүйрлэхээр байна. Энэхүү шовинист үзэл санаагаар Шведэд Самэн угсаатан, Австралид Абориген нутгийн иргэдийг, Америкт Индианчуудийг боловсон иргэншил, хөгжил дэвшил нэрийн доор тэдний шашин соёлыг устгаж хэмжээлшгүй гай зовлонд унагаасан юм.

2021 оны 3 сард болсон улсын их хурал дээр Ши Жиньпин үг хэлэхдээ:

„Үндэсний цөөнх болох Өвөр Монголчууд та нар Хан үндэстнээс салахгүй, Хан үндэстэн ч та нараас салахгүй гэдгийг цээжлэх хэрэгтэй“ гэжээ.

*Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн хурал дээр Жиньпин*



Орчуулга:

*Дотоод Монголын өөртөө засах орны засаг захиргаанаас хос хэлний сургалтын талаар явуулж буй үйл ажиллагаа нь буруу, дутуу, тодорхой бус байгаагаас гадна Хятадын төв засгийн шаардлагатай тохирохгүй байна.*

Өвөр Монголын засаг захиргааныхан Мандарин хэлний хэрэглээг эрчимжүүлж, үндэсний үзэл, үндэсний соёлыг засан залруулж, үндэсний цөөнхийн асуудлыг шийдвэрлэж, сургуулиудад Хятад орон даяр хэрэглэгддэг сурах бичгийг нэвтрүүлэхийг санууллаа.

Эхний ээлжид нийгэм, уран зохиол, түүхийн хичээлүүдийг хятад хэл дээр шинэ сурах бичгийн



дагуу сургахаар болжээ. Уг нь эдгээр хичээлүүд Монгол хэл, Монголын уран зохиол, Монгол соёлыг хүүхдүүдэд олгодог гол хичээлүүд байлаа. Мөн шинэ сурах бичгүүдэд „Монгол“, „Монголын тал“, гэх мэт үгсийг хасаж оронд нь „Хятадын тал нутаг“ гэдэг үгээр орлуулжээ.

Энэхүү шинэ сургалтын компани ажил нь Хан хятадыг сурталчилсан агуулгатай хэвлэл, радио, ТВ-ээр бүтээлүүдтэй хавсран явагдаж байна.

Эдгээр шинэ дүрэм, журмын хариуд Монгол сургуулийн сурагчид үндэсний хувцас болох дээлээ өмсөж, хүндлэлийг бэлгэдэл хадгаа барин сургуульдаа сүүлчийн монгол хэл дээрх хичээлдээ ирсэн байна. Энэ өдөр багш сурагчид хамтдаа эх хэлнийхээ хичээлүүдтэйгээ нүдэндээ нулимстай салах ёс гүйцэтгэжээ.

Энэхүү үндэсний цөөнхийн эрхийг хөсөрдүүлсэн шийдвэр нь Хятадын үндсэн хууль ба НҮБ-ийн тунхгийг зөрчиж байна.

**Хятад улс НҮБ-ийн тунхагт гарын үсэг зурсан боловч харин түүнийгээ батламжлаагүй юм.**

## **НҮБ-ийн тунхгийн 1-р зүйлд**

„Улс орнууд үндэсний цөөнхийн хэл соёл, шашин шүтлэгт хүндэтгэлтэй хандаж, түүнд зориулсан эрх зүйн орчин бүрдүүлэн хангахыг заажээ.

Ямартаа ч НҮБ-ийн тунхагт үндэсний цөөнх нь эх хэл дээрээ үр хүүхдээ сурган хүмүүжүүлэх, боловсрол олгох, уламжлал, шашин, соёлоо дэлгэрүүлэх эрхтэйг заажээ.

Тэр байтугай үндэсний цөөнх нь хэрвээ улс орны эрх ашигт харшилсан үйл ажиллагаа явуулаагүй бол хилийн гадна байгаа ахан дүүстэйгээ уулздаг байхаар заажээ.

<https://www.ohchr.org/EN/Issues/Minorities>

Хятад улсын үндсэн хуулийн 4 -р хэсэгт ч мөн дараах зүйлийг заажээ.

„All ethnicities have the

freedoms and rights to use and develop their own spoken and written languages and to preserve or reform their own folkways and customs.“

„Хятадын бүх үндэстнүүд эрх чөлөөтэй ба ярианы болон бичгийн хэлээ хэрэглэх, хөгжүүлэх эрхтэй“ гэжээ.

Radio Free Asia 2021.3.25-нд мэдээлснээр Хятадын улсын их хурлаас үндэсний цөөнхийн сурагчид дунд ангидаа өөрсдийн хэлээр суралцах нь хятадын үндсэн хуулийг зөрчсөн хэрэг гэжээ.

Ийнхүү Шинжаанд хэрэгжүүлсэн хос хэлний бодлого одоо Өвөр Монголд хэрэгжиж, дунд сургуулийн ангиас эхлэн бүх хичээлүүд зөвхөн хятад хэл дээр ордог болох гэж байна.

Хятадын энэ бодлогоор Зөвлөлт Холбоот улсын задралын шалтгаан нь өөрийн үндэстнүүддээ хэтэрхий их автономит эрх олгосноос болсон ба харин эсрэгээрээ АНУ-ын иргэд нэг хэлээр ярьдаг тул эв нэгдэлтэй байгаа гэж үзжээ. Ингэхдээ Америкийн цөөнхүүд нийгмийнхээ давхарга бүрт ялгаварлан гадуурхагдаж байгааг үл ойшоожээ.

[https://eacea.ec.europa.eu/national-policies/eurydice/sites/eurydice/files/minority\\_languages\\_de.pdf](https://eacea.ec.europa.eu/national-policies/eurydice/sites/eurydice/files/minority_languages_de.pdf)

малчдын хүүхдүүдэд Жиньпин эх хэлийг нь устгах халдлага явуулсан нь Хятадын үндсэн хууль ба НҮБ-ийн тунхгийг зөрчиж байна.

Энэхүү үйлдэл нь бас 1949 оноос хойш Өвөр Монголын өөртөө засах автономит засаглалын гэрээг зөрчиж байна. Өвөр Монголын өөртөө



## **ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХ**

*Үндэсний цөөнхийн эрхийг олон улсын хэмжээнд тодорхой бүлэг хүмүүсийн улс төрийн эрх гэж нийтээрээ заншаагүй. Энэ эрхийг Шлэсвиг-Х олштайн мужийн Дани гаралтай иргэдэд (мужийн 5%) олгогдсон байдаг нь ганц тохиолдол юм. Анх удаа 1976 онд иргэний ба улс төрийн эрхийг дэлхийн 176 НҮБ-ийн гишүүн орнууд баталгаажуулсан. Үүгээр үндэсний цөөнхийн эрхийг тодорхойлсон ба Хятад улс гарын үсэг зурсан боловч баталгаажуулаагүй юм. Европт 1992 онд орон нутгийн болон цөөнхийн хэлний асуудлаар тунхаг гаргасан. Гэхдээ энэ бол тунхаг юм. Франц, Их Британи, Грек улсууд баталгаажуулахдаа хойрго хандсан. Европын хүн амын 11% орчим нь өөрийн цөөнхийн хэлээр ярьдаг. Испанийн Каталон, Баскад Италийн өмнөд Тиролчууд блон Ладинууд, Австрид Словенүүд дээд сургууль хүртэлх боловсролоо өөрсдийн хэл дээр авдаг. Бельги, Ирланд ба Швейцарьт албаны хэл нь олон төрлийн хэл байдаг. Европт болон түүнтэй хил залгаа орнуудынхувьд гялалзсан бүхэн алт биш гэдэг заримдаа таардаг.*

## **УКРАЙН**

*Украинд баталсан шинэ хуулиар үндэсний цөөнхийн эрх хязгаарлагдсан. 2020 оноос эхлэн орос, румин, унгар хэлтэнгүүдийг украин хэл дээр хичээллүүлэхээр зохицуулж, эсвэл эх хэлийг нь гадаад хэл маягаар оруулахаар заажээ.*

## **ТУРК**

*Олон жилийн турш Турк улс курдуудын хэл соёлыг үгүйсгэсээр, дарангуйлсаар ирсэн. Турк улсад 20 сая курд хүн байдаг. Туркэд Курд сургууль огт байдаггүй. Туркүүд Курдуудыг „Уулын Туркүүд“ гэж нэрийдэж тэдний асуудлыг үгүйсгэдэг.*

засах тогтолцоогоор бол эдийн засаг, боловсрол, гэр бүлийн төлөвлөлт, өөрийн хэл бичиг, парламентад суух гишүүдийн тоо зэргийг өөрсдөө засан захирахаар зохицуулагдсан байдаг.

Одоогийн байдлаар Өвөр Монголд 25 сая хүн амьдарч байгаагийн 5-6 сая нь монгол хэлээр ярьдаг монгол хүн байна.

Өвөр Монголчууд нь Монгол улсын Монголчуудаас ч илүүтэйгээр Монгол өв соёлын тээгчид гэгддэг. Өвөр Монголын Хөх Хотын их сургууль бол Монголын өв соёлын судалгааны нэр хүндтэй байгууллага юм. Өвөр Монголчууд Монгол бичгээ тасралтгүй хэрэглэсээр, Монгол соёл, уламжлалаа хадгалсаар иржээ.

Өвөр Монголчуудын хэл яриа нь Монгол улсын Монголчуудын ярианы хэлнээс илүү сонгодог Монгол хэлд ойр юм. Өвөр Монголчууд бол Чингис хаанаа дээдэлдэг бөгөөд түүний тухай олон ТВ-олон ангит кино, нэвтрүүлэг хийсэн. Харин Орос болон Монгол улсад Чингис хааныг зэрлэг балмад алуурчин гэж үздэг үе байсан.

Өвөр Монголын автономит засаглал нь Хятадын талаас нэгэн нөхцөл болзолтойгоор хүлээн зөвшөөрөгддөг. Тэр бол Хятад улсын бүрэн бүтэн байдал юм.

Өвөр Монголчуудын автономит засаглал бол Хятад улсын бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрснөөр баталгаажсан юм.

Хятад улс „монголчуудын хэл соёл, бэлгэдлүүд нь Хятад улсын бүрэн бүтэн байдалд заналхийлж байна“ хэмээн хардаж тодорхой эсрэг үйлдлүүдийг (жишээлбэл зарим Рок хамтлагийн тоглолтыг хориглох мэт) явуулсаар иржээ. Гэхдээ эдгээр үйлдлүүд нь зөвхөн хоосон хардлагууд байлаа. Өвөр Монголд Ар Монголтой нэгдэх зорилготой нэрлэхээр улс төрийн хүчин, бүлэглэл өнөөдрийг хүртэл алга байна

Дундад улсын түүхэнд харьяаныхаа 55 үндэстнүүддээ явуулж ирсэн улс төрийн бодлого нь янз бүр байсан.

Зарим үед автономитийн өөртөө засах эрхийг эдлүүлж, зарим үед хэл соёл нь дарангуйлсан бодлого явуулж иржээ. Нэгэн цагт Хятадын эв хамтын намыг төв хороонд Улаанхүү гэж үндэсний цөөнхийн комисар байсан ба 1983-1988 оны хооронд Хятад улсын дэд ерөнхийлөгч болж байв. Түүний хүү, ач нар Өвөр Монголын өөртөө засах орны улс төрийн бодлогыг тодорхойлж явсан. Ач Бу Шиолин нь 2016 онд аймгийн дарга болсон.

Үндэсний цөөнхийн хэл соёлын асуудлыг Бээжингийн үндэсний их сургуулийг угсаатан зүйн факультет болон орон нутаг дахь бусад 23 боловсролын байгууллагууд судалдаг.

Хятадын үндэсний цөөнхөд, ялангуяа Өвөр Монголд явуулсан бодлогын талаар дараах линкнээс мэдээлэл авч болно.

[https://www.zo.uni-heidelberg.de/sinologie/shan/nl-archiv/2020\\_NL106\\_2.html](https://www.zo.uni-heidelberg.de/sinologie/shan/nl-archiv/2020_NL106_2.html)

## ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРОН БА ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙН БОДЛОГЫН ЯВЦ

Дараах мэдээллийг ардчилсан хөдөлгөөний тэмцэгч Ц.Мөнхбаяраас авсан юм.

1966-1976 оны Соёлын хувьсгалын үед Өвөр Монголд Монгол соёлын эсрэг хүчтэй компани ажил зохион байгуулж, монгол хүүхдүүдийг сургуульд сурч боловсрох боломжгүй болсон.

1978 онд монгол сургуулиудыг сэргээж эхэлсэн.

1979 онд сургуулиудыг хятадаар төлөвлөж байсан. Оюутан сурагчид багш нар хичээл хаялт зарлаж, үүнийг болиулж байв.

1980, 1986, 1992 онуудад бас хятадаар хичээллүүлэх оролдлогууд гарсан. Өвөр Монголд харин монгол хэл соёлдоо итгэл сэтгэлтэй сурган хүмүүжлийн салбарын монгол дарга нар ажиллаж байлаа. Тэд “улсын хэлийг сургах гэсэн ухагдахууныг хүлээж авна, гэхдээ Өвөр Монголын арга замаар хэрэгжүүлнэ” гэсэн хатуу байр суурин дээр зогсож, оролдлогууд няцааж байлаа.

2001 онд Дундад улсын нийтийн хэл, үсэг бичгийн тухай хууль баталж, хятад хэлийг “улсын хэл, нийтийн хэл” хэмээн урьд өмнөөс илүү хүчтэйгээр баталгаажуулжээ. Үүнээс хойш, уг хуулиар далайлган, “хос хэлний сурган хүмүүжил” гэх нэрийн дор цөөнх үндэстнүүдийн сургуулийг хятадаар хичээллүүлэхийг оролдож ирсэн.

2017 онд Шинжаанд, 2018 онд Төвөдөд цөөнх үндэстнүүдийн хүүхдүүдийг хятадаар хичээллүүлэх болсон юм. Шинжааны Ил талд

амьдардаг Монголчуудын хүүхдүүд ч мөн хятадаар хичээллэж эхэлсэн.

2020.6.4-нд, Түнляо хотод “хос хэлний сургалт” гэх нэрийн дор Монгол сургуульд хятадаар хичээл орох тухай мэдээг Free Asia радиостанци түгээсэн. Энэ явдал нь монголчуудын дунд их дургүйцлийг төрүүлээ.

Монгол хэлээр гарсан номыг интернетээр ерөөсөө худалдаж болохгүй” гэж анхааруулжээ. Ингэснээр монгол номын худалдаа эрс хумигдсан. Монгол ТВ-ийн контентүүдийн оронд хятад агуулгатай нэвтрүүлгүүд гарах болсон

Их тэмцэл эсэргүүцэл өрнөөд ирэхээр “Хятадаар хичээллүүлнэ гэх ямар ч бичиг шийдвэр гараагүй, хоёр гуравхан хичээлийг хятадаар туршиж оруулах гэтэл гадаад дотоодын дайснууд мушгин гуйвуулж, буруу ойлгуулж үймээн самуун дэгдээлээ” гэж мэлзсэн.

1-р ангид 2 хичээл (хятад хэл зохиолын болон хууль-ёсзүйн хичээл), 7-р ангид 1 хичээл (Хятадын түүх) хятадаар заана гэх болсон. Өмнө нь бол монгол хэлээрх сургалт байхгүй болно гэж ойлгогдож байсан.

Гэтэл бодит байдал дээр монгол багш нарыг олноор халж, хятад багш нарыг оронд нь оруулж, монгол хятад хүүхдүүдийг нэг ширээнд суулгаж, монгол сургууль гэх ойлголтыг алдагдуулан устгах ажиллагаа хагас нууц байдлаар явагдсаар ирлээ.

Дээлээ өмсөөд хичээлдээ суудаг байсан монгол балчир хүүхдүүдэд улаан хамгаалагчийн хувцас өмсүүлж хичээллүүлж байгаа зургууд түгсэн 2023 оноос монгол хэлээрх сургалт байхгүй болж, бүрэн хятад хэлээрх сургалтад шилжих төлөвтэй байгаа

Өвөр Монголын монгол сургуулиудад монгол түүх соёлыг заахыг болиулав. „Монгол түүх соёлыг заах нь Хятадын үндэсний эв нэгдэлд харш“ хэмээсэн.

„Өвөр Монголын түүх соёл“, „Монгол Үндэстний түүх“, „Хөлөнбуйрын түүх ба соёл“, „Бортохойн түүх ба соёл“, „Хорчины түүх ба соёл“



зэрэг монгол түүх соёлын номуудыг хурааж авч шатааж устгав.

## **Өвөр Монголчууд 2020 оны найм, ес дүгээр сард өвөр монголчууд эх хэл бичгийнхээ төлөө их тэмцлийг өрнүүлсэн**

8.26. Шилийн гол аймгийн Шулуун хөх хошууны монгол дунд сургуулийн Соёлт багш “Монгол хэл бичгийнхээ төлөө амь биеэ үл хайрлая” гэж уриалаад, эсэргүүцлийн тэмдэг болгож, гэртээ амиа хорлосон. Шилийн голд багш нар идэвхтэй тэмцсэн. Бүхэл бүтэн сургуулийн хамт олон тэр аяараа санаа нэгдэн, “хятадаар хичээллүүлэх бодлогыг дэмжихгүй” гэж мэдэгдэж, эсэргүүцлийн бичиг үйлдэн, бүгд гарын үсэг зурж, ажил хаясан тохиол ч гарсан.

8.30. Өвөр Монголд эцэг эхчүүд „дотуур байрнаас хүүхдээ авна“ гэж хаа сайгүй тэмцэв. Тунляо хотын Шивэртийн дунд сургуулийн гадна тийм тэмцэл өрнөх үеэр нэгэн эхийг цагдаа, хамгаалагч нар харгисаар зоджээ. Үүнийг харсан 5-р ангийн хүү нь хямран бачимдаж, „гаръя“ гэхэд гаргаагүй учир, „гаргахгүй бол цонхоор үсэрнэ“ гэжээ. Тэгсэн ч гаргаагүй учир цонхоор үсэрч, нас баржээ.

9.1. Хичээлийн шинэ жилийн нээлт Өвөр Монголын сургуулиудад болсонгүй. Жишээ нь Тунляогийн Найман хошууны нэг монгол сургуульд 1000 сурагч ирэх байсан бол, дөнгөж 10-40 сурагч иржээ.

9.2. Хүүхдээ дотуур байрнаас авч харих ба хичээлд явуулахгүй байх буюу бүх нийтийн хичээл хаялт, мөн жагсаал цуглаан, бусад тэмцлийг идэвхтэй өрнүүлсэн монголчуудыг Хятадад хоморголон баривчлав. Тэмцсэн иргэд нуугдав. 129 иргэнийг “аюултай дайсан” гэж Хятадын цагдаагийн газар 1000 юань амлан, эрэн сурвалжиллаа.

9.3. Алшаа аймгийн намын ажилтан 34 настай Сурнаа бүсгүй, Улаанхад хотын (Чифэн) Шинэсүм сумын төрийн албан хаагч залуу эсэргүүцэл илэрхийлэн амиа егүүтгэв.

9.4. „Одон“ ТВ-ийнхэн эсэргүүцэлд нэгдэв. Тус ТВ-ийн ихэнхи ажилтан монголчууд юм. Бүх 300 монгол ажилтан сургууль хятадаар хичээллэхийг эсэргүүцэж гарын үсэг зурав. Энэ тухайгаа видео мэдээ бэлтгэж, нийтийн сүлжээнд цацжээ. Төрийн албан хаагч монголчууд олноороо эх хэл бичгийнхээ төлөөх эсэргүүцэлд нэгдэв. Багш нар их үүрэг гүйцэтгэсэн.

9.6. Эцэг эхчүүд хүүхдүүдээ дотуур байрнаас авах гэхэд цагдаа цэргээр бүслэн өгөхгүй, барьцаалсан явдлууд гарсан.

Дотуур байрны хүүхдүүд зугтаж гарахад гадаа нь жагссан эцэг эхчүүдийг нь тараачихсан, тосох унаа тэрэг үгүй тул, хөдөө хээр, уул усыг гэтлэн гатлан, хол газар гүйж харьцаасан нь ч бий.

9.7. Хэл ус, ойлголцох байдал зэргээс болж, өвөр монголчуудтай холбоотой асуудалд өвөр монгол цагдаа нарыг илүүтэй оролцуулдаг. Гэтэл монгол цагдаа нар олноороо эсэргүүцэлд нэгдэж, өргөх бичиг үйлдэж, хурууны хээгээ дарцгаасан юм.

9.12. Эрээн хотын нэгэн монгол сургуулийн захирал Улаан эсэргүүцэл илэрхийлж, амиа хорлов.

9.14. Монгол хүүхдүүдийг аав ээжээс нь булааж, хүчээр “сургаж” эхлэв. Олзлогдсон хүүхдүүд ангидаа бүгдээрээ уйлж байгаа эмгэнэлт бичлэг түглээ. Албадан аваачсан хүүхдүүд олноороо оргосон.

9.7-оос эхлэн АНУ-ын Конгрессоор Өвөр Монголын асуудлыг хэлэлцүүлэхийн тулд, Монголын иргэд голцуу хүмүүс 100 000 гарын үсэг зурав.

### **ШИНЭ СУМ**

*001 оноос хойш малчид олноороо суурьшин амьдралд шилжсэн. Энэ нь 400 000 малчдыг суурин амьдралтай болгох хөтөлбөрийн хэрэгжилт юм.*

### **АЛШАА АЙМАГ**

*Энэ аймаг тэмээний ноосны нийлүүлэлттээр дэлхийд тэргүүлдэг. Тэмээний ноосыг дэлхийн зах зээлд гаргах угаах үйлдвэр Алшаагийн тэмээний ноос гэж бренд гаргаж нутаг бэлчээр оруулсан романтик реклам гаргаж байгаа.*



Монгол ном сурах бичгүүдийг хориглох тухай шийдвэр

9.16. Хятадчилахыг эсэргүүцэх хөдөлгөөнд бараг бүх өвөр монгол хүн хамрагдсан. Бүгдийг нь шийтгэнэ гэв.

Төрийн албанаас монголчуудыг халж, мэргэжил чадваргүй хятадуудыг оронд нь тавьж, тэд дураар дургих боллоо. Хувийн секторын хүмүүсийн худалдаа үйлчилгээний эрхийг хааж, өндөр торгууль оногдуулж, бас “эсэргүү хүн ажиллуулсан” гэж шийтгэх болов. Малчид зээл авч, аж ахуйгаа эрхлэх нь чухал байдаг. Гэтэл малчдад зээл өгөхөө больж, “зээлээ хурдан төл, эс бөгөөс шоронд хийнэ” гэв. Хүмүүсийн дансыг хааж, хадгаламжийг дээрэмдэв. Хуулийн ямар ч хамгаалалтгүй болгосон тул өвөр монголчуудын эсрэг дээрмийн голдуу гэмт хэрэг их үйлдэгдэх боллоо. Олон хүнийг шоронд хорьсон, ялласан, иргэний хөдөлгөөний идэвхтэн хүмүүст яаран 10 жилийн ял өгсөн явдал гарав. Амиа хорлосон эсэргүүцэгчдийн ар гэрийн хүмүүсийг үнэнийг хэлсний төлөө буруутгав, намын ажилтан бүсгүй Сурнаагийн нөхрийг “эхнэр солиорсон гэж гэрчилж гарын үсэг зур” гэхэд татгалзсан тул улсаа гүтгэсэн дайсан гэж шоронд хийсэн. Үр хүүхдийг нь олзлон булааж, эцэг эхийг нь “сурч боловсрох хүүхдийн эрхийг зөрчсөн” гэж буруутгах

Жининг/ Улаангав дүүрэгт болсон эсэргүүцлийн жагсаал ба цагдаа хүчнийхэн



# MONGOLEI RUNDBRIEF MÄRZ 2021

болов. Хүүхдээ сургуульд өгөөгүй явдлыг гаргасан бол нийгмийн халамж авах эрхийг нь хасна, хар дансанд бүртгэж, олон эрхийг нь хасна гэж мэдэгдсэн.

ICECC) хэлний эрхийн төлөө тайван эсэргүүцэлд оролцсон монголчуудыг суллахыг, дарамтлах, мөшгөхөө болихыг уриалжээ. Төрөлх хэлээрээ сурч боловсрохыг хязгаарлах замаар үндэсний цөөнхийг уусгах Хятадын бодлогыг буруушаажээ. ӨМӨЗО дахь эсэргүүцлийг сурвалжилсан Los Angeles Times сонины сэтгүүлч Элис Су-г баривчилсан, багалзуурдсан явдлыг эсэргүүцжээ

<https://www.dropbox.com/s/xye6bhhic0s4hqm/2020%20FCCC%20Report.pdf?dl=0>

Мөн адил төстэй явдал Германы сурвалжлагч Матиас Боэлингэрт тохиолджээ. Тэрээр хэлэхдээ:


Намайг Өвөр Монголд явж байхад баривчилж цаг хагас хорьсон. Тэд намайг Өвөр Монголоос гарч явахыг шаардсан. Тэдний шаардлагыг хүлээн зөвшөөрсний дараа л намайг сулласан гэжээ.

9.18. Үндэсний цөөнхийг цөөнхийг цэргийн албанд татдаггүй байсан бол, энэ жил Өвөр Монголд ихээр цэрэгт татлаа. 900 монгол цэрэг залууг Энэтхэгийн Ладактай хил залгаа нутагт байршуулжээ.

**9.29. Өвөр монгол тэмцэгч 9 хүн амиа алдаж, 10 000 орчим хүн баригдсан. Янз бүрийн шийтгэл, ял хүлээсэн.**

Тэмцэгч Янжиндуламыг “хятадчилах бодлогыг шүүмжлэв” гээд гэрийн хориог нь 10 жилийн ял

Сурнаа эсэргүүцлээ илэрхийлж амиа хорлов. Амиа хорлосон албан ёсны шалтгаан: Гутрал





*Нэгэн сургуулийн сурагчид шинэ сургалтыг эсэргүүцэж байна.*

болгож, яаран шоронд илгээсэн, эхнэрийнхээ үзэл санааг дэмжсэн гээд нөхрийг нь бас хорьсон. Нөхөр нь баривчлагдах хугацаагаа дуусгаад суллагдсан ч түүнд Янжиндуламын тухай нэг ч үг дуугарахыг хорьжээ.

300 мянган сурагч хятадчилах бодлогыг эсэргүүцсэн бойкотонд оролцсон байдаг. Эсэргүүцлээс болж бантахдаа БНХАУ хятадчилах аман шийдвэрээ үгүйсгэж, гурван хичээл л хятадаар оруулна гэж мэдэгдэх болсон. Гэсэн хэдий ч бодит амьдрал дээр Монгол хэл дээрх хичээл, сургалт системтэйгээр шахан зайлуулагдаж байна.

## **ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ ТӨЛӨВЛӨГӨӨ ЯВАГДАЖ БАЙНА УУ?**

Монголын тэгш өндөрлөг нь элсэн говиор дундуураа хоёр хуваагддаг.

Дотоод Монгол ба Гадаад Монгол гэдэг нэр томъёо 17-р зууны үеийн Чин гүрний үеийн нэршил юм. Дотоод Монгол нь Чингийн харьяанд

байсан ба говиос хойших Чин гүрнээс гадуур оршдог утгаараа „Гадаад Монгол“ гэж нэрлэсэн байдаг. Гадаад Монголд Ховдын хязгаар, Шинжаан, өнөөгийн Төвөд орно. Гадаад Монгол гэдэг нэр томъёо бол хуучирсан хэллэг бөгөөд дэлхийн 2-р дайны дараа Монгол улс НҮБ-ийн гишүүн орон болж хүлээн зөвшөөрөгдсөнөөс хойш хэрэглэгдэхгүй болсон.

Харин Өвөр Монголыг одоог хүртэл „Niі Měngg Zmzhmqū“ буюу “Дотоод Монголын өөртөө засах орон” гэж албан ёсоор нэрлэж байна.

Тэгвэл Монгол улсын Монголчууд бол Өвөр Монголын өөртөө засах орон гэж нэрлээд иргэдийг нь Өвөр Монгол, өвөрлөгч нар гэж нэрлэдэг.

Энэхүү нэр томъёоны цаана нэгэн зөрчил нуугдаж байгаа нь Европ-д Македони, Ар македони гэдэг нэр Грекийн харьяаны Македони хэмээх нэршилтэй ижил асуудал дагуулж байна.

Тэр ч байтугай Өвөр Монголын нутгийг “Хятадын тал” гэж өөрчлөх магадлалтай байна.



Umerziehung auf dem Land für Viehhalterinnen: „Einimpfen der allgemeinen chinesischen Identität“

## **УНШИХ НОМ, УРАН ЗОХИОЛУУДЫН ЗӨВЛӨМЖ**

*вөр Монгол бол 17. - р зууны дунд үеэс Чин улсын харьяанд орсон. Харин Монгол биш үндэстнүүд 20-р зуунаас эхлэн нутагшсан. Энэ бол Боксерүүдийн бослогын дараанаас эхэлсэн асуудал юм. Энэ нутагт хүмүүс суурьшуулж, тэднээс татвар авах бодлого хэрэгжсэн. Энэ тухай Удо Баркманы бичсэн Монголын түүх гэдэг ном байдаг.*

*Монголчуудын анд нөхдийн дунд алдартай „Говиор туулсан нууц ажиллагаа“ гэдэг Франц Мюллэнвэгийн номд монгол малчдын бэлчээрийг өмнө зүгийн цагаачид эзэмшихийг эсэргүүцэж байгаа тухай гардаг. Энэ номыг өнөөгийн улс төрийн байдалтай холбоотойгоор дахин уншихад ч таармаар байна.*

*Үүнээс 60 жилийн дараа газар эзэмшлийн асуудлаар гарсан өөр нэг ном бол „Чонын үе“ гэдэг ном. Энэ номын эхний бүлэгт соёлын хувьсгалын үед Өвөр монголд талын малчдын соёлыг устгах даалгавартай явсан нэгэн улаан хамгаалагчийн тухай түүх юм.*

## **ХЭЛ СОЁЛ, УЛАМЖЛАЛЫГ НЬ ДАРАНГУЙЛАХЫГ ЭСЭРГҮҮЦСЭН НЭЭЛТТЭЙ ЗАХИДАЛ**

Германд суудаг Монголчууд биднээс Өвөр Монголчуудын хэл, соёл, уламжлалыг нухчин дарж байгааг эсэргүүцэж, дэмжлэг хүссэний дагуу Берлин дэх Хятадын элчин сайдад илгээх нээлттэй захидлын загварыг татаж авах боломжтойгоор энд байрлуулж байна. Та бүхнийг нээлттэй захидлыг татаж аваад гарын үсгээ зураад Хятадын элчин сайдад илгээхийг хүсье!

**Айкэ Зайдал, 2021 оны 3 сар**